



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН П.САЙНЗОРИГ ТАНАА

МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025.08.19 № А-1/650
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 25 дугаартай албан бичигтэй танилцаад дараах мэдээллийг хүргүүлж байна.

Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно” гэж, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт “Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоох бөгөөд үүнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.” гэж тус тус заасны дагуу мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд арилжааны банкууд нь Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А-106/298 дугаар тушаалаар батлагдсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ыг мөрдөн ажиллаж байна.

Дээрх аргачлалын 3.4 дэх хэсэгт “Банк, эрх бүхий хуулийн этгээд нь зээл судлах үед болон зээл олгосноос хойш 1 жилийн хугацаанд зээлдэгчийн төлөх доор дурдсан шимтгэл, хураамжийг зээлийн бодит өртөгт оруулах талаар зээл хүсэгчид танилцуулна.” гэж заасан бөгөөд 3.4.1 дэх заалтад “Зээлдүүлэгчид төлөх зээлийн хүсэлт хүлээн авах, судлах, олгох, олгосны дараах хяналттай холбоотой бүх төрлийн шимтгэл, хураамж”, 3.4.2 дахь заалтад “Зээлдүүлэгчийн шаардлагаар даатгалын үйлчилгээнд төлөх хураамж. Үүнд орон сууцны ипотекийн зээл хамаарахгүй”, 3.4.3 дахь заалтад “Зээлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зээлдэгчийн гуравдагч этгээдэд төлөх үйлчилгээний төлбөр”, 3.4.4 дэх заалтад “Зээлдүүлэгч, нийлүүлэгч, зээлдэгч гэсэн 3 талын оролцоотой санхүүгийн түрээс, фидуцийн гэрээний зүйл (автомашин)-ийн нийлүүлэгчээс зээлдүүлэгчид төлж буй шимтгэл, хураамж” гэж зээлийн бодит өртөгт оруулан тооцох шимтгэл хураамжийн төрлийг тусгасан байна.

Зээлийн бодит өртөг нь зээлийн хүү, зээлийн эргэн төлөх хуваарь болон зээлийн үйлчилгээний шимтгэл хураамжийн хэмжээнээс хамаардаг ба хүүгийн хувь өсөх, эргэн төлөх давтамж нэмэгдэх, зээлийн хугацаа богиносгох, шимтгэл хураамжийн хэмжээ нэмэгдэх зэргээс шалтгаалан өсдөг үзүүлэлт бөгөөд “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ын 4.2 дахь хэсэгт “Банк, эрх бүхий хуулийн этгээд нь үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого, зардлыг багцын түвшинд удирдана” гэж заасан байна.

1525022491

Арилжааны банкууд нь зээлийн суурь хүүт гадаад, дотоод нийт эх үүсвэрийн зардал, зээлд ноогдох зардлын хувь хэмжээ, зээлийн эрсдэлийн сангийн зардал болон зээлд ноогдох ашгийн хувь хэмжээнд үндэслэн тогтоож, тухайлсан харилцагчид олгох зээлийн хүүг зээлдэгчийн зээлийн түүхэн үнэлгээ, зээлийн хугацаа, бизнесийн салбарын эрсдэл, зээлийн эрсдэлийн нэмэгдэл зэргийг харгалзан үзэж, тогтоодог байна.

Зээлийн шимтгэлийн хувь хэмжээг уламжлалт зээлийн хувьд зээлийн үйл ажиллагаа буюу зээлийн хүсэлт хүлээн авах, зээл хүсэгчид зөвлөгөө мэдээлэл өгөх, зээлийн судалгаа шинжилгээ хийх, шийдвэр гаргах, зээл олгох, зээлд явцын хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааны зардал болох зээлийн өргөдлийн хураамж, зээл олголтын шимтгэл, зээлийн мэдээллийн сангийн зардал, даатгалын зардал, барьцаа хөрөнгийн үнэлгээний зардал, нотариатын зардал, хөдлөх болон үл хөдлөх барьцаа хөрөнгийн улсын бүртгэлийн зардалтай уялдуулан тогтоодог бол онлайн сувгаар олгож буй зээлийн хувьд программ хангамж болон онлайн зээл хөгжүүлэлттэй холбоотой гарч буй зардлуудыг мөн нэмж тооцдог байна. Банкууд өөрийн бизнесийн стратеги төлөвлөгөө, зээлийн бодлоготой уялдуулан зарим зээлийн бүтээгдэхүүнд шимтгэл, хураамжаас чөлөөлөх бодлого баримталж ажилладаг байна.

Зээлийн шимтгэл, хураамжаас чөлөөлдөг бүтээгдэхүүний төрөл болон зээлийн шимтгэл хураамжтай холбоотой зээлдэгч, хэрэглэгчээс сүүлийн таван жилийн байдлаар ирүүлсэн гомдлын агуулга, тоог арилжааны банкуудаас гаргуулан авч, нэгтгэн хавсралтаар хүргүүлэв.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчид хадгаламж, зээлийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлнэ”, 6.5 дахь хэсэгт “Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчаас зөвхөн гэрээнд тусгасан шимтгэл, хураамжийг төлүүлэх бөгөөд өөрийн үзүүлсэн нэг төрлийн үйлчилгээнд үйлчилгээний шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй.”, 6.7 дахь хэсэгт “Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо өөрийн хянан зохицуулах чиг үүргийн хүрээнд банк, эрх бүхий хуулийн этгээдээс тогтоосон бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг бууруулахыг санал болгох, саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох бөгөөд энэ тухайгаа нийтэд мэдээлэх эрхтэй байна”, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт “Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, зээлийн хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно”, 19.10 дахь хэсэгт “Банкнаас олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Монголбанк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина” гэсэн заалтууд нь зээлийн шимтгэлийн харилцааг зохицуулахад хамаарч байна. Иймд зээлийн хүү, шимтгэл, хураамжийн хэмжээг банк өөрөө тогтоох эрхтэй боловч түүнийг нийтэд ил тод зарлан мэдээлж байх, зээлдэгчид бүрэн гүйцэд тайлбарлан ойлгуулсны үндсэн дээр тухайн зээлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх, харилцагчтай байгуулсан гэрээнд тусгаагүй шимтгэл, хураамжийг харилцагчаас шууд болон шууд бусаар төлүүлэхийг хориглосон зохицуулалттай байна.

Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр баталсан "Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын дагуу банкнаас эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй зарладаг болгох, зээлийн хүүгийн дээд хязгаарыг бизнесийн, хэрэглээний болон бусад

зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр төрөлжүүлэн судлах зорилгоор банк болон Монголын банкны холбоотой хамтран тус тогтоолын хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг Монголбанкнаас зохион байгуулан ажиллаж байна.

Арилжааны зарим банкнаас хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хадгаламжид тооцсон хүүгийн орлогод татвар ногдуулах нь банкны зээлийн бодит өртөгт сөрөг нөлөөтэй буюу зээлийн хүүг нэмэгдүүлж байгаа дүгнэлтийг ирүүлсэн бөгөөд энэхүү татварын бодлого нь дараах үндсэн шалтгаануудын улмаас банкны эх үүсвэрийн бүтэц, зээлийн хүүгийн түвшин тогтоход сөрөг нөлөө үзүүлж байгааг дурдсан байна. Үүнд:

1. Банкны эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлэх - Банкууд хадгаламж татахын тулд илүү өндөр хүү санал болгох шаардлагатай болж, үүнээс шалтгаалан үндсэн үйл ажиллагааны зардал нэмэгдсэнээр энэхүү зардлын өсөлтийг нөхөхийн тулд зээлийн хүүг нэмэгдүүлж байна;
2. Харилцагчид банканд хадгаламж байршуулах сонирхол буурч, эрсдэл болон өгөөж өндөртэй хөрөнгө оруулалт хийх – Хадгаламжийн хүүгийн орлогод 10 хувийн татвар ногдуулснаар хадгаламж эзэмшигчийн цэвэр орлогыг 10 хувиар бууруулж байгаа тул иргэдийн хадгаламжид хөрөнгө оруулах сонирхол буурах, улмаар банкны урт хугацаат эх үүсвэр багасаж, санхүүжилтийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Мөн харилцагч талаасаа крипто валют зэрэг илүү өгөөж, эрсдэл өндөртэй хөрөнгөд хөрөнгө оруулалт хийснээр санхүүгийн эрсдэлд орох магадлалыг нэмэгдүүлж байна;
3. Дотоод эх үүсвэр буурснаар банк өндөр хүүтэй гадаад эх үүсвэр татах нь зээлийн бодит өртгийг нэмэгдүүлэх - Дотоодын эх үүсвэр, хөрөнгө оруулалт хангалтгүй үед банк гадаад санхүүжилтээр шаардлагатай эх үүсвэрээ бүрдүүлдэг. Гадаад эх үүсвэрийн зардал өндөр байгаа нь зээлийн хүүгийн бодит өртгийг нэмэгдүүлж байна.

Монголбанк дахь статистик тоо мэдээгээр 2025 оны 05 дугаар сарын байдлаар арилжааны банк дахь иргэдийн нийт төгрөгийн хадгаламж 19.1 их наяд төгрөг байгаагаас 15.8 их наяд төгрөг буюу 83 хувийг хугацаатай хадгаламж бүрдүүлж байгаа бөгөөд үүнээс 13.1 их наяд төгрөг буюу 68 хувь нь 1 жил хүртэлх хугацаатай хадгаламж, 1.3 их наяд төгрөг буюу 8 хувь нь 1-3 жил хүртэлх хугацаатай хадгаламж, 1.4 их наяд төгрөг буюу 7 хувь нь 3 жилээс дээш хугацаатай хадгаламж байна.

Иргэдийн гадаад валютын нийт хадгаламж 2025 оны 05 дугаар сарын байдлаар 3.8 их наяд төгрөг байгаагаас 3.2 их наяд төгрөг буюу 84 хувийг хугацаатай хадгаламж бүрдүүлж байгаа бөгөөд үүнээс 2.6 их наяд төгрөг буюу 69 хувийг 1 жил хүртэлх хугацаатай хадгаламж, 564.3 тэрбум төгрөг буюу 15 хувь нь 1-3 жил хүртэлх хугацаатай хадгаламж, 5.8 тэрбум төгрөг нь 3 жилээс дээш хугацаатай хадгаламж байна.

Арилжааны банкуудын банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад олгосон зээлийн үлдэгдэл 2025 оны 05 дугаар сарын байдлаар 492.7 тэрбум төгрөг байгаагаас 484.4 тэрбум төгрөг буюу 98.3 хувь нь хэвийн ангилалтай, 8.3 тэрбум төгрөг буюу 1.7 хувь нь анхаарал хандуулах болон чанаргүй ангилалтай зээл байна. Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад сүүлийн таван жилд олгосон зээлийн эргэн төлөлтийг банкуудаас гаргуулан авч харахад эдгээр зээлүүдийн 30.5-98 хувь нь эргэн төлөгдсөн байна.

Арилжааны банк дахь иргэдийн хугацаатай хадгаламжийн мэдээ болон банкуудын банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад олгосон зээлийн үлдэгдлийн сүүлийн 5 жилийн мэдээг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 5 хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

Монголбанкны 2025 оны 0.8 дугаар сарын 19 өдрийн А-1/230 тоот албан бичгийн хавсралт



Хүснэгт 1 - Зээлийн шимтгэл, хураамжтай холбоотой гомдол

Д/д	Банкны нэр	Зээлийн үйлчилгээний шимтгэл хураамжтай холбоотой гомдлын төрөл	Гомдлын тоо /оноор/					Нийт
			2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	
1	Хаан банк	зээлийн шимтгэл хураамж			367	197	37	601
		онлайн зээлийн шимтгэл хураамж			2,349	1,359	420	4,128
2	Ариг банк	зээлийн үйлчилгээний шимтгэлийн талаарх гомдол	1		1			2
		картын хураамж, шимтгэлийн тухай гомдол	1					1
		интернэт банкны гүйлгээний шимтгэлийн тухай гомдол			1			1
		ариг онлайн аппликейшны нэвтрэх пин код шимтгэлийн тухай гомдол			2	1	2	5
		данс хөтөлсний хураамжийн тухай гомдол		1			2	3
		яаралтай бэлэн мөнгө авахад шимтгэлийн тухай гомдол		1				1
		валютын шимтгэлийн тухай гомдол		1		2		3
		мессеж мэдээ үйлчилгээний шимтгэлийн тухай гомдол				1		1
		тендерийн баталгааны хураамжийн тухай гомдол					1	1
3	М банк	зээлийн эрх шалгах хураамж давхар авсныг буцаах				25	96	121
		зээл олголт давхардаж, илүү суутгасан олголтын шимтгэлийг буцаах				-	7	7
		картын захиалга хийгдэхэд хураамж илүү суутгасныг буцаах				5	-	5
		данс хаах хүсэлтийн дагуу шимтгэл суутгасан боловч данс хаагдаагүй				5	11	16
		хуулга, тодорхойлолтын шимтгэл суутгасан боловч тодорхойлолт илгээгдээгүй тул шимтгэл буцаах				16	58	74
		мэдэгдэл очоогүй ч суутгасан шимтгэлийг буцаах				3		3

4	Худалдаа хөгжлийн банк	змс лавлагааны хураамж /цахим зээлийн хүсэлт/				4		4
		зээл судалсны шимтгэл	3	1	9	5	2	20
		зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан шимтгэл		1			1	2
		зээлийн даатгалын хураамж	1		3	3		7
		хадгаламж барьцаалсан зээл хаасан шимтгэл	1	1	1			3
5	Хас банк		2	1	2	1	1	7
6	Төрийн банк		1	4	3	5	4	17
7	Голомт банк	2022.07.01-2025.06.30-нд гомдол бүртгэгдээгүй						-
8	Тээвэр хөгжлийн банк	гомдол бүртгэгдээгүй						-
9	Богд банк						1	1
10	Капитрон банк				1			1
НИЙТ			10	11	2,739	1,632	643	5,035

Хүснэгт 2 - Зээлийн шимтгэл, хураамж тогтоодоггүй зээлийн бүтээгдэхүүний мэдээ

Д/д	Банкны нэр	Банкнаас ирүүлсэн шимтгэл, хураамж тогтоодоггүй зээлийн бүтээгдэхүүний тайлбар
1	Хаан банк	Ногоон зээл, тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгмийн хариуцлагад чиглэсэн зарим зээлийн бүтээгдэхүүнүүдийн хувьд зээл олгох үйлчилгээний шимтгэлээс чөлөөлдөг.
2	Худалдаа хөгжлийн банк	<u>Зээл олголтын шимтгэл тооцдоггүй:</u> 1. Кредит карт 2. Тэтгэврийн зээл 3. Тэтгэвэр барьцаалсан зээлийн эрх 4. Хадгаламж барьцаалсан зээл 5. Хэрэглэний ногоон зээл
3	Хас банк	Зээлийн өргөдлийн хураамж авдаггүй буюу тэг төгрөгөөр тогтоосон.
4	Голомт банк	Тайлбар ирүүлээгүй.
5	Төрийн банк	Төрийн банкны одоо мөрдөж буй нөхцөлийн хувьд “Хадгаламж барьцаалсан зээл”-д хураамж авдаг бол бусад бүх төрлийн зээлийн бүтээгдэхүүний хувьд хураамжгүй ба зээл олголтын шимтгэлийг зээлийн бүтээгдэхүүний төрлөөс хамааран 0.3%-1.0% байхаар тогтоосон.
6	Капитрон	<u>Зээл олголтын шимтгэл тооцдоггүй иргэдийн зээл:</u> Алтны урьдчилгаа зээл, тэтгэврийн зээл, малчны зээл, хадгаламж барьцаалсан зээл, богино хугацаат онлайн зээл, орон сууцны зээл, Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэгч нарт зориулсан зээл.

		<p><u>Зээл олголтын шимтгэл тооцдоггүй ААН-ийн зээл:</u> Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэгч нарт зориулсан зээл, алтны урьдчилгаа зээл, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл, орон нутгийн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээл, ногоон орон сууцны зээл</p>
7	М банк	<p><u>Зээл олголтын шимтгэл тооцдоггүй:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. М кредит пэй зээлийн эрх
8	Ариг банк	<p>Ариг банк нь бүх төрлийн зээлийн бүтээгдэхүүн дээрээ зээлийн үйлчилгээний шимтгэл, хураамж тогтоодог бөгөөд уг шимтгэл хураамжийг зээлийн судалгаа хийж шийдвэр гарган зээлийг олгох хүртэлх хугацаанд банкнаас гаргаж буй зардал болон өрсөлдөгчийн харьцуулсан судалгаанд үндэслэн шимтгэл хураамжийг тогтоодог болно.</p>
9	Богд банк	<p><u>Бизнесийн дараах төрлийн зээлүүдэд зээлийн өргөдлийн хураамж болон зээл олголтын шимтгэл тооцдоггүй:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Онлайн КҮБ-ын орлого барьцаалсан зээл- хураамжгүй. 2. Овернайт зээл- шимтгэлгүй, хураамжгүй. 3. Техник, тоног төхөөрөмжийн зээл- шимтгэлгүй, хураамжгүй. <p><u>Хэрэглээний дараах зээлийн бүтээгдэхүүнд зээлийн өргөдлийн хураамж болон зээл олголтын шимтгэл тооцдоггүй:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Тэтгэврийн зээл 2. Урьдчилсан хүүт хугацаатай хадгаламж барьцаалсан зээл 3. Хүүхдийн хадгаламж барьцаалсан зээл 4. Онлайн зээл- шимтгэлтэй, хураамжгүй
10	Тээвэр хөгжлийн банк	<p><u>Зээлийн өргөдлийн хураамж болон зээл олголтын шимтгэл тооцдоггүй бүтээгдэхүүн:</u></p> <ul style="list-style-type: none"> • Урамшуулалт 6 сартай хадгаламж барьцаалсан зээл • Хувьсах хүүтэй хадгаламж барьцаалсан зээл • Хөрвөсөн хадгаламж барьцаалсан зээл • Ханшийн эрсдэлээс хамгаалагдсан хадгаламж барьцаалсан зээл • Хадгаламж барьцаалсан зээл • Хеджэд хадгаламж барьцаалсан зээл <p><u>Зээл олголтын шимтгэл авдаггүй бүтээгдэхүүн:</u> /эдгээрээс ЗМС-ийн лавлагааны хураамж, өргөдлийн хураамж болон зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд шимтгэл авна/:</p> <ul style="list-style-type: none"> • Бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл • Ажилтны цалингийн зээл • Ачилтын дараах зээл • Ачилтын өмнөх зээл

Хүснэгт 3 - БАНКУУДЫН ИРГЭДЭЭС ТАТСАН ХАДГАЛАМЖИЙН МЭДЭЭ

сая төгрөгөөр

	2024 оны 12-р сар				2025 оны 5-р сар			
	Төгрөг		Гадаад валют		Төгрөг		Гадаад валют	
	Дүн	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн	Дансны тоо
ИРГЭДИЙН ХАДГАЛАМЖ	18,751,379	3,370,098	3,380,101	235,053	19,138,456	3,456,945	3,774,659	238,507
ХУГАЦААГҮЙ	3,519,034	1,863,797	556,967	184,721	3,347,178	1,915,432	614,458	187,186
<i>Нийт</i>								
<i>хадгаламжид</i>	<i>19%</i>	<i>55%</i>	<i>16%</i>	<i>79%</i>	<i>17%</i>	<i>55%</i>	<i>16%</i>	<i>78%</i>
<i>Эзлэх хувь</i>								
ХУГАЦААТАЙ	15,232,344	1,506,301	2,823,134	50,332	15,791,278	1,541,513	3,160,201	51,321
<i>Нийт</i>								
<i>хадгаламжид</i>	<i>81%</i>	<i>45%</i>	<i>84%</i>	<i>21%</i>	<i>83%</i>	<i>45%</i>	<i>84%</i>	<i>22%</i>
<i>Эзлэх хувь</i>								
<i>1 жил хүртэл</i>	<i>12,467,961</i>	<i>1,102,795</i>	<i>2,363,194</i>	<i>43,388</i>	<i>13,061,738</i>	<i>1,116,983</i>	<i>2,590,089</i>	<i>44,247</i>
<i>Эзлэх хувь</i>	<i>66%</i>	<i>33%</i>	<i>70%</i>	<i>18%</i>	<i>68%</i>	<i>32%</i>	<i>69%</i>	<i>19%</i>
<i>1-3 жил хүртэл</i>	<i>1,416,306</i>	<i>146,421</i>	<i>454,351</i>	<i>6,149</i>	<i>1,308,542</i>	<i>158,649</i>	<i>564,279</i>	<i>6,325</i>
<i>Эзлэх хувь</i>	<i>8%</i>	<i>4%</i>	<i>13%</i>	<i>3%</i>	<i>7%</i>	<i>5%</i>	<i>15%</i>	<i>3%</i>
<i>3 жилээс дээш</i>	<i>1,348,078</i>	<i>257,085</i>	<i>5,589</i>	<i>795</i>	<i>1,420,998</i>	<i>265,881</i>	<i>5,832</i>	<i>749</i>
<i>Эзлэх хувь</i>	<i>7%</i>	<i>8%</i>	<i>0%</i>	<i>0%</i>	<i>7%</i>	<i>8%</i>	<i>0%</i>	<i>0%</i>

Хүснэгт 4 - БАНКУУДЫН БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН МЭДЭЭ
сая төгрөгөөр

	2020.12.31	2021.12.31	2022.12.31	2023.12.31	2024.12.31	2025.05.31
ХЗХ-д олгосон зээл	5,744.03	4,483.29	2,726.68	436.93	3,336.00	3,483.08
Хэвийн зээл	5,735.30	4,479.00	2,726.68	436.93	3,336.00	3,483.08
Төгрөгийн	5,735.30	4,479.00	717.00	436.93	3,336.00	3,483.08
Гадаад валютын	-	-	2,009.68	-	-	-
Анхаарал хандуулах зээл	-	-	-	-	-	-
Төгрөгийн	-	-	-	-	-	-
Гадаад валютын	-	-	-	-	-	-
Чанаргүй зээл	8.72	4.29	-	-	-	-
Хэвийн бус зээл	-	-	-	-	-	-
Төгрөгийн	-	-	-	-	-	-
Гадаад валютын	-	-	-	-	-	-
Эргэлзээтэй зээл	-	-	-	-	-	-
Төгрөгийн	-	-	-	-	-	-
Гадаад валютын	-	-	-	-	-	-
Муу зээл	8.72	4.29	-	-	-	-
Төгрөгийн	8.72	4.29	-	-	-	-
Гадаад валютын	-	-	-	-	-	-
ББСБ-д олгосон зээл	27,911.40	68,570.96	104,881.87	151,558.74	504,369.71	489,285.18
Хэвийн зээл	21,715.15	61,346.48	97,734.68	143,036.75	496,494.47	480,975.88
Төгрөгийн	21,185.13	60,816.58	92,788.21	143,036.75	479,393.22	463,106.13
Гадаад валютын	530.03	529.89	4,946.47	-	17,101.25	17,869.75
Анхаарал хандуулах зээл	-	868.29	-	299.91	-	105.47
Төгрөгийн	-	868.29	-	299.91	-	105.47
Гадаад валютын	-	-	-	-	-	-
Чанаргүй зээл	6,196.24	6,356.19	7,147.20	8,222.08	7,875.24	8,203.83
Хэвийн бус зээл	-	0.02	906.03	634.41	933.92	964.78
Төгрөгийн	-	0.02	906.03	-	297.73	300.00
Гадаад валютын	-	-	-	634.41	636.19	664.78
Эргэлзээтэй зээл	800.00	-	0.02	316.67	-	-
Төгрөгийн	800.00	-	0.02	316.67	-	-
Гадаад валютын	-	-	-	-	-	-
Муу зээл	5,396.24	6,356.17	6,241.15	7,271.00	6,941.32	7,239.06
Төгрөгийн	4,398.92	6,356.17	6,241.15	7,271.00	6,941.32	7,239.06
Гадаад валютын	997.32	-	-	-	-	-